



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2024 оны 06 сарын 27 өдөр

Дугаар 149

Улаанбаатар хот

Нээлттэй сонгон шалгаруулалтад шалгарсанд тооцож,
тусгай зөвшөөрөл олгох тухай

Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.5 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэг, Радио долгионы тухай хуулийн 5¹ зүйлийн 5¹.1.8 дахь заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны 114 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “2024 онд олгох өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо” болон тус хорооноос 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдөр зарласан “Орон нутагт арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалт АРР-Орон нутаг 2024/01”-ийн үнэлгээний ажлын хэсгийн 2024 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн санал, дүгнэлтийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Тус хорооноос зарласан Орон нутагт арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох АРР-Орон нутаг 2024/01 тоот нээлттэй сонгон шалгаруулалтад Монгол монголчуудын сонсдог ном НҮТББ-ыг шалгарсанд тооцсугай.
2. Сонгон шалгаруулалтад шалгарсан Монгол монголчуудын сонсдог ном НҮТББ-т “Арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх” болон “Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах” тусгай зөвшөөрлийг энэхүү тогтоолын хавсралтад заасан хугацаа болон хамрах хүрээнд олгосугай.
3. Тусгай зөвшөөрөл олгох тухай шийдвэр хүлээн авсан этгээд түүнийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор гэрээ байгуулах үүрэгтэй болохыг дурдсугай.
4. Тусгай зөвшөөрөл олгосон этгээдтэй тусгай зөвшөөрлийн гэрээ байгуулах, энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ЧИНЗОРИГ

ГИШҮҮД

Ч.ЗОЛБАЯР

А.ЛУВСАН-ОЧИР

Н.МАНДАХБААТАР

Харилцаа холбооны зохицуулах хорооны
2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн
149 тоот тогтоолын
хавсралт

Тусгай зөвшөөрөл олгосон хуулийн этгээдийн
жагсаалт

№	Хуулийн этгээдийн нэр	Хамрах хүрээ, Үйлчилгээний хүртээмж	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа
1	Монгол монголчуудын сонсдог ном НҮТББ	Завхан аймгийн нутаг дэвсгэрт “Арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрөл Завхан аймгийн Улиастай сумын нутаг дэвсгэрт “Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах” тусгай зөвшөөрөл Ашиглах давтамж: 87.9 МГц	2024.06.27	2029.06.27

----- оОо -----